



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/310

Булган сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Ж.Ганбат (ГВ61101411)-ын Булган сум 6 дугаар баг Залуус 1 дүгээр гудамж 100 тоотод байршилтай 6308003709 нэгж талбар бүхий аж ахуйн зориулалтаар эзэмшиж буй 5433 м2 газрын газар эзэмших эрхийг Г.Мөнхболд (ГВ88110612)-д, Д.Пунсал (ГЮ64122869)-ын Булган сум 6 дугаар баг Залуус 8 дугаар гудамж 800 тоотод байршилтай 6308002896 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 672 м2 газрын газар эзэмших эрхийг Ж.Батдорж (ГЮ82112613)-д, М.Мөнхзориг (ЖЯ88041476)-ийн Булган сум 6 дугаар баг Залуус 14 дүгээр гудамж 1422 тоотод байршилтай 6308004581 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 700 м2 газрын газар эзэмших эрхийг Д.Түмэнхүү (КЮ98081019)-д, Д.Туяа (ГА66011367)-гийн Булган сум 6 дугаар баг Залуус 5 дугаар гудамж 516 тоотод байршилтай 6308005110 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 725 м2 газрын газар эзэмших эрхийг Б.Пүрэвсайхан (ГЗ83033111)-д тус тус шилжүүлсүгэй.

2.Г.Мөнхболд, Ж.Батдорж, Д.Түмэнхүү, Б.Пүрэвсайхан нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/373 дугаар захирамжийн Ж.Ганбат, 2017 оны А/496 дугаар захирамжийн Д.Пунсал, 2020 оны А/261 дүгээр захирамжийн М.Мөнхзориг, 2022 оны А/460 дугаар захирамжийн Д.Туяа нартай холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

